

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол орноо дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлж, ардчилал, сайн засаглал, хариуцлагатай байдлыг эрхэмлэн хэрэгжүүлж, олон улсын тавцанд сайн нэр бүхий байж, шинжлэх ухаан, судалгаа, иргэдийн оролцоонд үндэслэн тогтвортой хөгжлийн зам дээр бат зогссон, өөрийн өв соёл, тусгаар тогтнол бүрэн эрхт байдлаа улам бэхжүүлсэн, хүн ам нь эрх чөлөөтэй, өндөр ёс зүйтэй, аз жаргалтай орон болгон хөгжүүлэхэд ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН мөрийн хөтөлбөрийн зорилтууд чиглэх болно.

Энэхүү зорилтдоо хүрэхийн тулд тууштай ажиллаж шинэ цаг үеийг авчрах дэвшилтэт улс төрийн нам байна. Ингэхдээ өмнөх үеийнхээ гүйцэтгэж байсан төрийн ажлын залгамжийг алдалгүй үргэлжлүүлэхийн ялдамд шинэ, дэвшилтэт дараах үндсэн өөрчлөлтийг манлайлах болно. Үүнд:

- **Монголчууд илүү хариуцлагатай, сайн засаглалтай болж, шударга хөдөлмөр, эрдэм мэдлэг, ёс зүй өндрөөр үнэлэгддэг болно.** Нийтийн боловсрол, ёс зүйн төлөвшил, үнэт зүйлсийн нэгдмэл байдлыг хангаж үндэсний аюулгүй байдал, эв нэгдэл, зөвшилцлийн суурийг бэхжүүлнэ.
- **Иргэдийн идэвхтэй оролцоотойгоор тогтвортой хөгжлийн загварыг эдийн засгийн бүх талбарт бий болгоно.** Байгаль орчин хамгаалах, цөлжилттэй тэмцэх, дэлхийн дулаарлын үр дагаврыг багасгах талаар бүх шатанд хэлэлцэж тогтвортой шийдлийг дэмжиж ажиллана.
- **Санхүүгийн сахилга бат, төсвийн нээлттэй байдал сайжирч, банк санхүүгийн тогтолцооны найдвартай, аюулгүй байдал эрс нэмэгдэнэ.** Олон улсын хар, саарал жагсаалтад ордоггүй улс болохын төлөө өөрчлөлт хийнэ. Олон улсад банк санхүүгийн харилцаагаа харилцан хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө идэвхтэй ажиллаж эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах валютын нөөцийг нэмэгдүүлнэ.
- **Хүний эрхийн байдал эрс сайжирна.** Хүний эрхийг хангах шалгуурыг улс төр, эдийн засаг, төрийн оролцоотой бүх талбарт тавьж, нийгмээ бүхэлд нь хүнд ээлтэй болгон өөрчилнө.
- **Илүү ногоон, илүү цэвэрхэн Монгол орныг цогцлооно.** Ногоон хөгжлийг дэмжиж, хог хаягдлын менежментийг шинэ түвшинд гаргаж, аюултай хог хаягдлыг онцгойлон анхаарч төрийн зохих шийдвэрүүдийг шат дараатай гаргуулан, аюултай хог хаягдлын чимээгүй аюулыг зайлуулна.

- **Гадаад харилцааг хөрш орнууд, гуравдагч хөрш болон бүс нутгийн хэмжээнд идэвхжүүлж, олон улсын харилцаанд эх орныхоо эрх ашгийг хамгаалан оролцоно.** Дэлхийн эдийн засгийн их хямрал, хүн төрөлхтний өмнө тулгарч буй байгаль орчин, нийтийн эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэхэд Монгол орон өөрийн чадлаар хувь нэмэр оруулах талаар хичээн ажиллах манлайллыг хэрэгжүүлж, олон улсад дэмжлэг авч ажиллана. Нүүрсний гадаад худалдаанд гарч буй олон улсын урт хугацааны бодлогын өөрчлөлтийг харгалзан үзэж эдийн засгийг цаашид бусад чиглэлээр тэлэх бодлого явуулна.

НЭГ. АРДЧИЛАЛД ТУУШТАЙ УЛС ТӨРИЙН НАМ БАЙНА

Аюулгүй байдлын цогц бодлогыг хэрэгжүүлэхдээ иргэдийнхээ эх оронч үзэл, төр иргэний хамтын ажиллагаа, мэдлэг судалгаа, дүн шинжилгээнд суурилсан бодитой хандлагыг баримталж, даяаршлын хүчин зүйлийг харгалзан үндэсний ашиг сонирхлоо бататгаж ажиллана.

Үндэсний аюулгүй байдлын нэгэн баталгаа болсон ардчиллын удаан оршин тогтнол, тогтвортой байдлыг баталгаажуулахын төлөө ажиллана.

Улс төрийн санхүүжилтийг өртөг багатай болгох чиглэлд санал, санаачилга гаргаж, өөрийн үйл ажиллагаагаар үлгэрлэн манлайлна.

Засгийн Газар, Шүүх, УИХ, улс төрийн нам зэрэг төр, улс төрийн аливаа институцийг хараат бус үйл ажиллагаа явуулж, бие даасан байдлаа бэхжүүлэхэд нь чиглэсэн тууштай бодлогыг урт хугацаанд баримталж ажиллана.

Төсвийн зарцуулалтыг УИХ, Засгийн газар бүрэн хариуцаж, ард түмний өмнө хариуцлагаа хүлээхийг тууштай дэмжиж, Ерөнхийлөгчийн институцийг улс төрийн хагарал, тэмцлээс ангид байлгана.

ХОЁР. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ НАМ БАЙНА.

Ковидын үеийн хямрал, ковидын дараах эдийн засгийн хүнд сорилтод улс орноо нэгдмэл зорилготой байлгах, иргэд, аж ахуйн нэгж, Засгийн газрыг хязгаарлагдмал нөөцөө ухаалаг зөв зарцуулахад нь чиглэл өгөх, урт хугацааны өсөлтийг бий болгох эрүүл, тогтвортой эдийн засгийн бүтцийг бүрдүүлэхэд онцгой анхаарч ажиллана.

Тогтвортой хөгжлийг буй болгоход зайлшгүй шаардлагатай нийгмийн бүх талын харилцан ойлголцол, иргэдийн дадал болон ухамсрын өөрчлөлт, кластерын талуудын хамтын ажиллагааг бүх талаар дэмжинэ.

Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтөд дасан зохицох, сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх үндэсний чадавхыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд олон улсын санхүүгийн механизмыг өргөн ашиглаж, бүх талын оролцоог хангах арга хэмжээ авна.

Бэлчээрийн уламжлалт мал аж ахуйг хэвээр хадгалах хэр нь, зах зээлийн эргэлтийг түргэсгэх, усны нөөцийг түшиглэсэн хадлангийн аж ахуйг иргэний оролцоотойгоор

хөгжүүлэх замаар нүүдэлчин соёл иргэншлээ уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицуулж авч үлдэх, хөдөөгийн амьдралын чанарыг дээшлүүлэх, талаар томоохон өөрчлөлт гаргахыг хөхиүлэн дэмжинэ.

Нүүдэлчин малчдын аж ахуйн тойрогт тохирсон, орон нутгийн иргэдийн төлбөрийн чадвар, хамтран ажиллах горимд нийцэхүйц, үндэсний үйлдвэрлэлийн чадавхыг удаан хугацаанд тогтвортой өсгөж ажиллаж чадах, өртөг багатай улирлын үйлдвэрлэл бүхий бизнесийн зохион байгуулалтыг хөгжүүлнэ.

ГУРАВ. САЙН ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИГЧ, ХЭРЭГЖҮҮЛЭГЧ УЛС ТӨРИЙН НАМ БАЙНА

Эдийн засгийн дотоод нөөцийн маань нэгэн үүц нь засаглалын нөөц. Бидэнд байгалийн баялаг хангалттай бий. Харин хариуцлага, сайн засаглал хангалттай бус байна. Ийм учраас эдийн засгийнхаа дотоод нөөцийг жинхэнэ утгаар нь зохистой ашиглахын тулд хариуцлага, санхүүгийн сахилга бат, ажил хийх өндөр соёлыг хослуулсан сайн засаглалыг түгээж, дэлгэрүүлж, сурталчилж, өөрсдөө манлайлан хэрэгжүүлнэ.

Монголоор овоглосон бүтээгдэхүүн бүхэнд сайн засаглалыг шингээхийн төлөө ард түмнээ уриалан ажиллана. Үр дүн, процессын аль аль нь Монгол улсын сайн нэрийг буй болгодог болно. Ингэснээр малчны хотоос ч, аймаг, сум, хороо, дүүргээс хаанаас ч бий болсон бүтээгдэхүүн дэлхийн зах зээлийн өндөр шалгуурыг хангадаг болох чанарын өөрчлөлтийг эхлүүлнэ.

ДӨРӨВ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ЭРХЭМЛЭГЧ, ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЛЭГЧ НАМ БАЙНА

Хүний эрхийг хамгаалагч нам байна. Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг иргэддээ чөлөөтэй эдлүүлэхийн төлөө тууштай ажиллана.

Монгол хүний удмын санг хамгаалах, гэр бүлийн болон хүн ам зүйн хөгжилд жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн төсөл хөтөлбөрийг санаачилж дэмжинэ. Өөрсдийн үйл ажиллагаа, шийдвэр гаргах түвшний оролцоонд жендерийн тэгш байдлыг буй болгож манлайлна.

ТАВ. ТӨРИЙН АЛБЫГ МЭРГЭШСЭН, ЁС ЗҮЙТЭЙ, ХЭМНЭЛТТЭЙ, ҮР БҮТЭЭЛТЭЙ БОЛГОЖ ҮЛГЭРЛЭГЧ УЛС ТӨРИЙН НАМ БАЙНА

Төрийн албыг улс төржилтөөс хамгаалах, мэргэжлийн хүмүүсийг төрд олноор шийдвэр гаргах түвшинд ажиллуулах талаар идэвхтэй ажиллах ёстой. Бид үүнийг аль ч засгийн газрын үед шаардаж ажиллах болно.

Төрийн цэргийн бодлогод эх орныхоо өмнө журамт үүргээ биелүүлэн цэргийн алба хааж буй иргэдийнхээ эсрэг харгислал, хүчирхийлэл хэрэглэхийг хатуу хориглосон үзэл санааг нэвтрүүлнэ.

Төрийн албан хаагчдад тавих мэргэжил мэдлэгтэй байх, ёс зүйтэй, өндөр үр бүтээлтэй, нийтийн эрх ашгийн төлөө ажиллах шаардлагыг өөрөө үлгэрлэн биелүүлэгч нам байна.

ЗУРГАА. ГАДААД ХАРИЛЦААГ ӨРГӨЖҮҮЛЭГЧ НАМ БАЙНА.

Олон улсын харилцаанд Монгол улсаа нүүр бардам байр суурьтай байлгаж, дэлхийн улс орнуудтай найрсгаар хамтран ажиллаж эдийн засагтаа олон гадаад боломжуудыг нээхийн төлөө ажиллана.

Дипломат албаны мэргэшсэн байдлыг эрс дээшлүүлж тэнд улс төрийн томилгоо, хариуцлагагүй байдлыг таслан зогсоохын төлөө хатуу зогсох болно. Дипломат албанд шилдэг эх орончид ажиллах ёстой гэдэг алтан зарчмыг баримтлах болно. Зөвхөн өндөр ур чадвартай мэргэшсэн эх орончдоос бүрдсэн дипломат албаны хүчээр л Монголын нэр хүнд олон улсын түвшинд өсөж, улмаар эдийн засаг, соёлын харилцаа өргөжих боломжтой. Дипломат албадыг улс төрчдийн амралтын газар биш харин улс орныхоо төлөө цаг наргүй ажилладаг манлайлагчдын тэргүүн фронт болгохыг зорьж ажиллана.

ДОЛОО. ХУВИЙН ХЭВШЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ НАМ БАЙНА

Хувийн хэвшлийг байнга дэмжиж ажиллана. Хувийн хэвшлийг кластераар хөгжих шинэ боломжийг бий болгохын төлөө ажиллана. Хувийн хэвшлийг нийгэмчлэхийн эсрэг байр суурь баримтална. Харин төрийн өмчийг хувьчлахыг дэмжиж ажиллана. Зохисгүй монопол гарсан тохиолдолд түүнийг нийгэмчлэх аргаар биш, хувийн хэвшлийг өргөтгөх аргаар шийдвэрлэх замыг сонгоно.

Нийтийн өмч, газар, лиценз зөвшөөрлийг хувийн хэвшил ашиглах, худалдан авах, дахин худалдах, эргэлтэд оруулахтай холбоотой харилцаан дээр үүссэн зөрчил нь хувийн хэвшил болон нийтийн эрх ашгийн эсрэг тэсрэг тэмцэл рүү хөтлөх таагүй үр дагавраас урьдчилан сэргийлэх зах зээлийн үр өгөөжтэй хэр нь нийтийн эрх ашигт нийцэх механизмуудыг санаачилна. Тухайлбал лиценз шилжүүлсний төлбөр, арилжааны төлбөр, бүртгэлийн хураамж, экологийн нөхөн төлбөр зэрэг олон арга хэрэгсэл ашиглах боломжийг санал болгох замаар урт хугацаанд хувийн хэвшилд түшиглэсэн эдийн засгийн суурийг баталгаажуулна.

НАЙМ. ҮНДЭСНИЙ ӨВ СОЁЛ, НИЙТИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЛГЭРҮҮЛЭГЧ НАМ БАЙНА.

Үндэсний өв соёлыг хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, хөгжүүлэх үйлсийг бүх нийтийн үйлс болгох чиглэлд манлайлан ажиллана.

Төрийн албан хаагчдын монгол бичиг, хүний эрхийн мэдлэг, нийтийн боловсролыг дээшлүүлнэ.

Үндэсний соёлын өв, соёл иргэншил, оюуны сан, чадавхыг арвижуулагч, дэлгэрүүлэгч, түгээгчдийг алдаршуулна.

Нийт иргэдийн хувийн ариун цэвэр, хувийн зохион байгуулалт, хувийн эрүүл мэнд, шинжлэх ухааны мэдлэг боловсролыг байнга өндөр хэмжээнд байлгах ёстой гэж үзэж хүн амынхаа аюулгүй байдлын төлөө нийтийн боловсролыг нэн дээшлүүлэхэд анхаарна. Ямар ч хүнд нөхцөлд ажил хөдөлмөрөө эрхэлж чаддаг, орлогоо олж чаддаг, хүүхэд залуусынхаа боловсролыг хоцрогдолгүй байлгаж чаддаг улс орон болно.

Газарзүйн алслалт, нийгмийн эрүүл мэндээс үүдсэн хөл хорионоос үл хамааран бизнес, ажил хэрэг эрхлэх, эвлэлдэн нэгдэх, кластер үүсгэх зэрэг эрх, эрх чөлөөгөө эдлэхэд хамгийн хүртээмжтэй арга хэрэгслүүдийг дэмжин түгээн дэлгэрүүлнэ. Үүний дотор цахим технологийг нам өөрийн үйл ажиллагаандаа нэн тэргүүнд авч хэрэгжүүлнэ. Цахимаар ажиллах бүх нийтийн ур чадварыг эрс нэмэгдүүлнэ. Цахим ажил хэргийн соёлыг тууштай нэвтрүүлнэ.

ЕС. ХУУЛИЙН ЗАСАГЛАЛЫГ ХЭВШҮҮЛЭГЧ УЛС ТӨРИЙН НАМ БАЙНА

Хуулийн засаглалын эсрэг нэг хүний захиран тушаах арга хэлбэрийг ашиглахыг цээрлэгч нам байна. Монголчууд бид ямар ч асуудлыг дүрэм журам, хуулийн хүрээнд шийдвэрлэдэг байхыг Үндсэн хуульдаа тунхагласан. Энэхүү хуулийн засаглалын хэм хэмжээг улам бэхжүүлэн хэвшүүлэгч байхыг бүхий л үйл ажиллагаандаа эрхэмлэнэ. Төрийн шийдвэр гаргагч нь хуулиар олгогдоогүй эрх мэдлийг өөртөө бий болгохыг санаархах аливаа оролдлогыг хийдэггүй байлгахын төлөө ажиллана.

АРАВ. НИЙТИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ ҮЙЛСИЙГ ДЭЛГЭРҮҮЛЭГЧ НАМ БАЙНА

Иргэний идэвхтэй оролцоо, санаачилгаар нийгэмд гарч болох эерэг өөрчлөлтүүд олон бий. Хөгжлийн бүх өөрчлөлтөд төр оролцох албагүй бөгөөд харин иргэдийн санаачилж буй өөрчлөлтөд төр саад болдоггүй байх ёстой гэж үзнэ. Мөн иргэдийн санаачилсан зөв горимоор өрнөж буй өөрчлөлтийг төр оролцож бусниулах, тогтвортой бус хэлбэрт шилжүүлэх, төсвийн мөнгөөр хэт кампаничилж үр ашиггүй болгохын эсрэг байна. Эрх чөлөөтэй, ёс зүйтэй, нийтийн эрх ашгийн төлөө сэтгэлтэй иргэдийн хийж буй өөрчлөлтийн органик өсөлтөд зөвхөн шаардлагатай арга хэрэгслээр туслах, урт хугацааны тогтвортой байдлыг нь дэмжих замаар нийтийн сайн сайхны төлөөх үйлсийг дэлгэрүүлэгч нам байна.